

Зохиогч: Edward Hughes

Зураглаач: Byron Unger; Lazarus

Найруулсан: M. Maillot; Sarah S.

Орчуулсан: Damdin Norolsuren

Бүтээсэн: Bible for Children

www.M1914.org

©2014 Bible for Children, Inc.

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**



**Есүсийг
баптизм
хүртэж байх
үед Бурхан
тэнгэрээс
"Энэ бол
миний
хайртай
хүү.**



**Түүнд
миний
таалал
оршдог"
гэв. Бурхны
АРИУН СҮНС
Есүс дээр
тагтаа адил
буув.**



**Удалгүй
Бурхны Ариун
Сүнс Есүсийг
зэлүүд газар
уруу дагуулав.**



**Есүс
ганцаараа
байлаа.**



**Есүс дөчин өдөр мацаг
барьжээ. Энэ нь тэр ямар
ч хоол идээгүй гэсэн үг.
Тэр маш их өлсжээ.**



**Библи дээр зэрлэг амьтад
ч тэнд байсан гэж
бичигдсэн байдаг.**



**Муу сүнс болох Сатан
Есүсийг сорихын тулд
түүн дээр
ирэв.**



Дээр үед тэр муу сүнс
Бурхны цэцэрлэг Еден
цэцэрлэгийг устгахын
тулд Адам
Ева хоёрыг
сорьж
байсан
юм.



**Харин одоо Есүсийг
сорихоор иржээ.**



Сатан Бурхны
хүү Есүсийг
хүртэл сорих
ГЭЖ ХИЧЭЭВ.



**Муу сүнс "Хэрэв чи
Бурхны Хүү мөн юм бол,
Энэ чулууг талх болго"
гэв. Тэр Есүсийг өлсөж
байгааг мэдсэн байжээ.**




**Тэр Бурхны Хүү чулууг
талх болгох чадалтай
гэдгийг мэдэж байв.
Есүс Муу сүнсний
үгэнд орсон болов
уу?**



**Үгүй ээ! Есүс муу сүнсний хэлснээр
хийгээгүй. Харин хариуд нь Бурхны
үгээр хариулсан.**



**"Хүн зөвхөн талхаар бус Бурхны
амнаас гарах үг бүрээр амьдарна"
гэж бичигдсэн байдаг гэв.**




**Дараа нь Сатан Есүсийг агуу хот
Иерусалемын хүмүүс мөргөл өргөдөг
ариун сүмийн орой
дээр аваачив.**




Тэгээд Сатан юу гэсэн бол оо?



"Хэрэв чи Бурхны Хүү мөн юм бол,
доошоо үсэр" гээд Муу сүнс "Түүний
үгэнд тэнгэр элч нар ирж чамайг
аварна" гэж гардаг
биз дээ гэв.



"Үгүй!" гэж Есүс хариулав. "Чи өөрийн Бурхан Эзнийг бүү сорь гэж бас байдаг" гэв.







**Муу сүнс дахин сорих
гэж хичээв. Тэр Есүсийг
хотын хамгийн өндөр
уулын оргил дээр авч ирэв.**




Есүст дэлхийн бүх
хаанчлал болон
бүх сүр хүчийг
үзүүлээд ...



**... "Хэрэв чи надад
мөргөвөл энэ бүхнийг
чамд өгөх болно" гэж
Муу сүнс хэлэв.**



"Зайл Сатан аа!" гэж Есүс тушаав.



**"Чи зөвхөн өөрийн Бурхан Эзэндээ
мөргөж түүнд үйлчил гэж
бичигдсэн байдаг" гэв.**



**Тэгээд Муу
сүнс түүнийг
орхив. Гэтэл
гайхамшигтай
зүйл
болов.**



**Бурхан Муу сүнсийг
дагаагүй өөрийн
хүү Есүсийг
тайвшруулж
үйлчлүүлэхээр
тэнгэр
элчүүдийг
илгээв.**



Есүст учирсан сорилт

Бурханы үг Библээс авсан түүх

Матай 4, Лук 4

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Төгсөв



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг
бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж
хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж
хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь
үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир
Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн
өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг
зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс
дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та
Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал
гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр
таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн
та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.



**Хэрвээ та энэ үнэнд итгэж
байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй:
Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон
миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та
амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж
ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос
эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр
тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд
дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө
амьдрахад туслаач. Амен.**

**Библи уншиж өдөр бүр Бурхантай
ярилцаарай! Иохан 3:16**

